

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 09 дүгээр
сарын 23-ны өдөр

Дугаар 272

Улаанбаатар хот

Г Хорооны 2009 оны 11 дүгээр сарын 23-ны 7
өдрийн 253 дугаар тогтоолоор батлагдсан журамд
нэмэлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 36.1, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 253 дугаар тогтоолоор батлагдсан “Харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам”-ын 3.1-д заасан “Сэжигтэй гүйлгээг мэдээлэх маягт”-ыг 1 дүгээр хавсралтаар, 4.1-д заасан “Бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх маягт”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тогтоолоор батлагдсан “Харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам”-ын батлагдсан маягтуудыг олон нийтэд мэдээлж, хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн мэдээллийн албанд мэдэгдсүгэй.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН